

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код : ОРА-2022 /3/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
ТУХ	Төслийн удирдах хороо



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 73
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. 2021 оны төсвийн жилд хэмнэлтийн горимд шилжүүлэх Засгийн газрын тогтоол гарсан байтал урсгал санхүүжилтийн зардлаас 30,317.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ"-ний тухай 43 дугаар тогтоолын 1.4-т "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж,

хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй.

2. Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/704 дүгээр захирамжаар "Чанарын менежментийн тогтолцоо" ISO 9001:2015 стандартын дотоод аудиторын сургалтад хамрагдах 6 албан хаагчийн сургалтын төлбөрт 2,700.0 мянган төгрөгийг Ворлд стандарт консалтинг ХХК-д шилжүүлэхдээ 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдөр, 2021 оны 12 дугаар 24-ны өдөр 2 давхар шилжүүлж, илүү шилжүүлсэн төлбөрийг буцааж төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, тайлант оны зардлаар тайлагнаж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй.

3. Албан томилолтын зардлаас 6,765.1 мянган төгрөгийг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, томилолтын хуудас очиж ажилласан газрын тэмдэглэл хийгдээгүй, томилолтын зардлаас олгосон шатахууны зардлыг жолоочийн хувийн дансанд шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны баримт дутуу, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй.

4. Засаг даргын нөөц сан нь тусдаа санхүүгийн тайлан тайлагнадаггүй, тусдаа данснаас гүйлгээ хийдэггүй, төрийн сангийн үндсэн харилцах дансны 210901 ангиллаас зардлын гүйлгээ гарч, ЗДТГ-ын санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд нэгтгэдэг байхад аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч нь сар бүр нөөц сан хариуцсаны 40%-ын нэмэгдэл 327,944 төгрөг, жилийн турш 3,935,328 төгрөгийн нэмэгдэл авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц сангийн журмын 6.3-т "Нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй.

5. Мөнгөн кассаар дамжуулан зарцуулсан 9,994.5 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байдал нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, ЗДТГ-ын ажилтнууд хүлээн авснаар гарын үсэг зурсан, Засаг даргын

захирамжид дурдсан иргэний ар гэр хүлээн авсан эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>625,050,894.46</u>	<u>777,368,564.40</u>
33	АВЛАГА	23,500,000.00	-
335	Бусад авлага	23,500,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	23,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	601,550,894.46	777,368,564.40
351	Түүхий эд материал	472,576,341.06	309,571,122.00
35110	Тусгай зориулалттай материал	472,576,341.06	309,571,122.00
354	Хангамжийн материал	128,974,553.40	467,797,442.40
35410	Бичиг хэргийн материал	13,305,051.00	19,632,600.00
35420	Аж ахуйн материал	30,328,256.40	39,993,660.40
35430	Сэлбэг хэрэгсэл	560,000.00	14,976,000.00
35440	Түлш, шатах тослох материал	691,446.00	-
35450	Барилгын засварын материал	46,605,000.00	351,710,382.00
35470	Бусад хангамжийн материал	37,484,800.00	41,484,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,867,077,352.78</u>	<u>5,990,929,501.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,867,077,352.78	5,990,929,501.46
392	Биет хөрөнгө	4,219,335,664.23	3,949,130,692.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,183,059,702.48	3,183,059,702.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(169,727,826.97)	(251,605,460.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	759,033,332.60	764,588,888.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(384,281,293.00)	(500,792,712.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,490,714,078.84	1,479,328,669.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(870,027,348.92)	(918,253,553.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	698,764,232.07	640,597,276.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(488,199,212.87)	(447,792,117.29)
39301	Програм хангамж	285,999,000.00	331,099,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(171,217,311.45)	(200,260,191.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,532,960,000.00	1,910,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,492,128,247.24</u>	<u>6,768,298,065.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,492,128,247.24</u>	<u>6,768,298,065.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,492,128,247.24	6,768,298,065.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,643,523,998.91	4,021,523,998.91
51101	Өмч: - төрийн	3,643,523,998.91	4,021,523,998.91
512	Хуримтлагдсан үр дүн	729,050,074.54	627,219,893.16
51210	Өмнөх үеийн үр дүн	729,050,074.54	729,050,074.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	(101,830,181.38)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,119,554,173.79	2,119,554,173.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,492,128,247.24</u>	<u>6,768,298,065.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,093,157,266.00	3,611,115,254.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	732,329,565.00	862,553,255.20
120	Нийтлэг татварын бус орлого	732,329,565.00	862,553,255.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	732,329,565.00	862,553,255.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,779,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	259,000.00	1,958,533.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	727,291,065.00	860,594,722.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,360,827,701.00	2,748,561,999.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	797,606,601.00	110,990,899.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	617,562,880.00	9,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,145,628.00	35,974,456.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,898,093.00	65,216,443.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,563,221,100.00	2,637,571,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,563,221,100.00	2,637,571,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,003,408,238.47	3,709,808,496.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,003,408,238.47	3,709,808,496.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,809,441,814.42	3,373,282,918.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,145,547,641.00	1,070,653,241.48
210101	Үндсэн цалин	844,348,445.40	973,448,217.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,294,514.78	88,986,910.00
210105	Гэрээт ажлын хөлс	248,904,680.82	8,218,114.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,861,542.64	132,235,459.07
210201	Тэтгэврийн даатгал	88,293,814.90	100,530,237.73
210202	Тэтгэмжийн даатгал	9,029,800.00	6,459,553.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,255,503.91	3,272,188.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,287,696.09	3,528,485.64
210205	Эрүүл мэндийн даатгал	18,994,727.74	18,444,992.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,832,077.31	72,033,453.69
210301	Гэрэл, цахилгаан	22,257,356.00	20,765,494.00
210302	Түлш, халаалт	29,653,058.11	35,974,018.62
210303	Цэвэр, бохир ус	10,921,663.20	15,293,941.07
2104	Хангамж, бараа материалын зардал	154,724,998.00	322,075,844.78
210401	Бичиг хэрэг	51,411,532.00	55,717,300.00
210402	Тээвэр, шатахуун	61,444,207.00	52,942,505.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,864,509.00	12,532,046.78
210404	Ном, хэвлэл	2,764,000.00	3,876,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,808,000.00	40,039,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,432,750.00	156,968,393.00
2105	Нормативт зардал	21,781,070.00	19,793,693.00
210502	Хоол, хүнс	6,206,070.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,575,000.00	19,793,693.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,625,875.00	76,187,247.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,300,000.00	22,610,997.00

Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210602	Тавилга	22,700,000.00	2,625,000.00
210604	Урсгал засвар	73,625,875.00	50,951,250.00
2107	Томилолт, зочны зардал	100,614,517.00	36,965,010.00
210702	Дотоод албан томилолт	38,176,797.00	35,390,910.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	62,437,720.00	1,574,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,300,751.00	168,345,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	539,746,651.00	134,402,064.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,752,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	13,417,000.00	13,414,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	913,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	315,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,320,900.00	9,749,750.00
210807	Газрын төлбөр	14,749,200.00	9,866,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,499,153,342.47	1,474,993,905.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	935,946,557.00	940,720,112.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,945,375.00	40,925,903.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	486,261,410.47	493,347,890.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,966,424.05	336,525,577.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,721,800.00	151,351,481.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,192,500.00	47,565,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114,529,300.00	103,786,181.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	53,890,624.05	185,174,096.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,890,624.05	185,174,096.65
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,354,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,354,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>89,749,027.53</u>	<u>(98,693,241.89)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37,892,224.38	3,136,939.49
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,136,939.49
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	37,892,224.38	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(37,892,224.38)	(3,136,939.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>51,856,803.15</u>	<u>(101,830,181.38)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,643,523,998.91	2,119,554,173.79	729,050,074.54	6,492,128,247.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,643,523,998.91	2,119,554,173.79	729,050,074.54	6,492,128,247.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,643,523,998.91	2,119,554,173.79	729,050,074.54	6,492,128,247.24
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,643,523,998.91	2,119,554,173.79	729,050,074.54	6,492,128,247.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн одлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,643,523,998.91	2,119,554,173.79	729,050,074.54	6,492,128,247.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	378,000,000.00	-	-	378,000,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(101,830,181.38)	(101,830,181.38)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,021,523,998.91	2,119,554,173.79	627,219,893.16	6,768,298,065.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,389,366,201.00	2,774,020,532.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,038,500.00	1,958,533.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,038,500.00	1,958,533.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,038,500.00	1,958,533.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,038,500.00	1,958,533.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,384,327,701.00	2,772,061,999.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	821,106,601.00	134,490,899.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	661,062,880.00	9,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,145,628.00	59,474,456.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,898,093.00	65,216,443.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,563,221,100.00	2,637,571,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,563,221,100.00	2,637,571,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,314,195,101.00	2,717,183,097.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,314,195,101.00	2,717,183,097.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,095,101,304.95	2,381,276,219.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,150,067,144.00	1,070,653,241.48
210101	Үндсэн цалин	844,348,445.40	973,448,217.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,294,514.78	88,986,910.00
210105	Гэрээт ажлын хөлс	253,424,183.82	8,218,114.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,861,542.64	132,235,459.07
210201	Тэтгэврийн даатгал	88,293,814.90	101,899,819.14
210202	Тэтгэмжийн даатгал	9,029,800.00	6,459,553.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,255,503.91	3,275,548.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,287,696.09	3,740,938.87
210205	Эрүүл мэндийн даатгал	18,994,727.74	16,859,598.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,832,077.31	72,033,453.69
210301	Гэрэл, цахилгаан	22,257,356.00	20,765,494.00
210302	Түлш, халаалт	29,653,058.11	35,974,018.62
210303	Цэвэр, бохир ус	10,921,663.20	15,293,941.07
2104	Хангамж, бараа материалын зардал	137,827,068.00	376,194,855.78
210401	Бичиг хэрэг	40,720,400.00	46,941,870.00
210402	Тээвэр, шатахуун	56,853,809.00	40,916,439.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,886,509.00	16,988,746.78
210404	Ном, хэвлэл	835,000.00	1,670,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,808,000.00	60,675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,723,350.00	209,002,800.00

Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	21,946,840.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	6,206,070.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,740,770.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,954,200.00	103,735,253.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,142,380.00	24,909,995.00
210602	Тавилга	36,500,000.00	4,680,000.00
210604	Урсгал засвар	98,311,820.00	74,145,258.00
2107	Томилолт, зочны зардал	93,293,517.00	35,390,910.00
210702	Дотоод албан томилолт	38,176,797.00	35,390,910.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	55,116,720.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556,395,250.00	138,578,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	516,672,650.00	104,584,710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,752,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	13,417,000.00	13,414,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,350,000.00	913,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	315,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,139,400.00	9,800,050.00
210807	Газрын төлбөр	14,749,200.00	9,866,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	775,923,666.00	451,455,036.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	689,257,091.00	387,841,133.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	86,666,575.00	63,613,903.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,093,796.05	335,906,877.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,349,172.00	150,732,781.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,192,500.00	47,565,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,156,672.00	103,167,481.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,854,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,854,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	53,890,624.05	185,174,096.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,890,624.05	185,174,096.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>75,171,100.00</u>	<u>56,837,435.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	56,837,435.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	56,837,435.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	56,837,435.00
222001	Тоног төхөөрөмж		56,837,435.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(56,837,435.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	75,171,100.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 03/117 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар аймгийн ЗДТГ-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхээр, Үүнд:

- /33.1.1./ харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;
- /33.1.2./ Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах;
- /33.1.3./ Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- /33.1.4./ хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- /33.1.5./ Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- /33.1.6./ төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- /33.1.7./ тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,637,571.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 39,563.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70%-иар 27,694.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **276,169.8** мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	23,500.0	-	(23,500.0)
Бараа материал	601,550.9	777,368.6	175,817.7
Үндсэн хөрөнгө	5,867,077.4	5,990,929.5	123,852.2
Нийт хөрөнгө	6,492,128.3	6,768,298.1	276,169.8
Өр төлбөр	-	-	
Хуримтлагдсан үр дүн	729,050.1	627,219.9	(101,830.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,492,128.3	6,768,298.1	276,169.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 26,520.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 30,317.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, хөрөнгө оруулалтаар 187,428.6 мянган төгрөгийн хөрөнгө, бусад биет бус хөрөнгөд 378,000.0 мянган төгрөгийн газрыг нэмж орлогоор бүртгэсэн.
- Бараа материал дансны тусгай зориулалтын бараа материалаас 92,920.9 мянга, бичиг хэргийн материал 531.9 мянган төгрөг нийт 93,452.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 609,993.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 675,095.2 мянган төгрөгийн бараа материал хандив тусламж, бусад байгууллагаас шилжүүлэн авснаар бүртгэсэн байна.
- Татаас санхүүжилтийн авлага 23,500.0 мянган төгрөг тайлант онд бүрэн барагдсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн ЗДТГ-ын орон нутгийн төсвөөс санхүүжих орлогыг 3,154,975.9 мянган төгрөг, зардлыг 3,154,975.9 мянган төгрөгөөр тооцож төсвийн саналыг хүргүүлсэн байна. Хүргүүлсэн төсвийн саналаас 517,404.8 мянган төгрөгөөр бууруулж 2,637,571.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг 2,637,571.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,637,571.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 1,958.5 мянган төгрөг, нийт 2,639,529.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эрх нээгдэж, урсгал зардалд 2,454,771.3 мянган төгрөг зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,454,771.3 мянган төгрөг буюу 98.11 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 74,638.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 22,121.2 мянган төгрөг, тогтмол зардал 6,762.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 68,044.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орхон аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар Архивын ерөнхий газраас 17,566.5 мянган төгрөг, Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны ерөнхий шалгалтын зардалд 6,408.0 мянга, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хог хаягдлыг бууруулах арга хэмжээний зардалд 10,000.0 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаас авто машинуудын засварын зардалд 9,800.0 мянга, Соёлын яамнаас соёл урлагийн менежментийн чадавхыг бэхжүүлэх бүсчилсэн уулзалтын зардалд 2,000.0 мянга, цэргийн дүйцүүлэх албаны орлого 63,642.9 мянга, архивын үйл ажиллагаанд бий болсон орлого 1,573.5 мянга, нийт 110,990.9 мянган төгрөгийн орлого төвлөрчээ.

Үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 17,150.7 мянга, бичиг хэрэгт 2,873.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 700.0 мянга, урсгал засварт 9,800.0 мянга, төрийн албаны салбарын зөвлөлийн урамшуулал 16,408.0 мянга, нормын хувцас 1,000.0 мянга, ариутгалын зардал 3,650.0 мянга, тавилга эд хогшил, багаж техник хэрэгсэлд 38,646.9 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 6,500.0 мянган төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим сайтад нийт 151 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийн хугацаа болоогүй. 149 мэдээллийг мэдээлсэн. Харин 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээнээс 209,684.4 мянган төгрөгийн 6 ажил гүйлгээ, зарлагын гүйлгээнээс 106,767.3 мянган төгрөгийн 8 ажил гүйлгээ орхигдуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн боловч зарим мэдээллийг оруулаагүй, харин Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 6,439.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 24,689.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 12,940.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт-4

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	6,439.5	3	6,439.5	-		
Албан шаардлага	3	24,689.4	3	24,689.4	-	-	-
Зөвлөмж	3	12,940.0	3	12,940.0	-		-
Нийт дүн	9	44,068.9	9	44,068.9			-

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 397,391.9 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 23,500.0 мянган төгрөгийн 1 залруулга хийж, 2,700.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 367,463.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 3,728.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулагдаагүй 7 алдааны зөрчлийн дүн 373,891.9 мянган төгрөг ба үүнээс 316,451.7 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг материаллаг бус гэж үзсэн, харин үлдсэн 6 алдаа зөрчлийн 57,440.2 мянган төгрөгийг материаллаг зөрчил гэж үзсэн.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 39,563.7 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчлийн дүн хэтэрсэн тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа: Өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 23,500.0 мянган төгрөгийг тайлант оны хүлээн зөвшөөрөх орлогоор буруу бүртгэж тайлагнасан.

4.2 Төлбөрийн акт:

- Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/704 дүгээр захирамжаар “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартын дотоод аудиторын сургалтад хамрагдах 6 албан хаагчийн сургалтын төлбөрт 2,700.0 мянган төгрөгийг Ворлд стандарт консалтинг ХХК-д шилжүүлэхдээ 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдөр, 2021 оны 12 дугаар 24-ны өдөр 2 давхар шилжүүлж, илүү шилжүүлсэн төлбөрийг буцааж төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, тайлант оны зардлаар тайлагнаж төсвийг үр ашиггүй

зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан шилжүүлсэн 2,700.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

- Шилэн дансны цахим сайтад нийт 151 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийн хугацаа болоогүй. 149 мэдээллийг мэдээлсэн. Харин 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээнээс 209,684.4 мянган төгрөгийн 6 ажил гүйлгээ, зарлагын гүйлгээнээс 106,767.3 мянган төгрөгийн 8 ажил гүйлгээ орхигдуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим сайтад орхигдуулсан, буруу, дутуу мэдээлсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэв.

- Мөнгөн кассаар дамжуулан зарцуулсан буцалтгүй тусламжийг олгосон байдал анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, ЗДТГ-ын ажилтнууд хүлээн авснаар гарын үсэг зурсан, Засаг даргын захирамжид дурдсан иргэний ар гэр хүлээн авсан эсэх нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй зардал гаргаж байгаа зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэв.

- Засаг даргын нөөц сан нь тусдаа санхүүгийн тайлан тайлагнадаггүй, тусдаа данснаас гүйлгээ хийдэггүй, төрийн сангийн үндсэн дансны 210901 ангиллаас зардлын гүйлгээ гарч, ЗДТГ-ын санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд нэгтгэдэг байхад аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч нь сар бүр нөөц сан хариуцсан гэж 40%-ын нэмэгдэл 327,944 төгрөг, жилийн турш 3,935,328 төгрөгийн нэмэгдэл авсан нь 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц сангийн журмын 6.3-т “Нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн чиг үүргийн ажлаа хийснээс гадуур нэмэлт ажил хийсэн гэж 40%-ийн нэмэгдэл авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант жилд 30,317.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ”-ний тухай 43 дугаар тогтоолын 1.4-т “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант онд 6,765.1 мянган төгрөгийн томилолтын хуудас байхгүй, ажилласан газрын тэмдэглэл хийгдээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, дутуу байхад томилолтын зардал олгосон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардалтай холбоотой

Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.9-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хор зэрэг зардлыг бууруулах” гэж заасан байтал бичиг хэргийн зардалд 40,340.4 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 44,068.4 мянган төгрөг зарцуулж 3,728.0 мянган төгрөг хэтрүүлж ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол шийдвэр, дүрэм журмыг чанд мөрдөн, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн урсгал зардлыг хэмнэлттэй зарцуулж байх.

2. Урсгал зардалтай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд сэлбэг хэрэгсэлд 15,114.9 мянган төгрөг, автомашины дугуй худалдан авахад 10,560.0 мянган төгрөг, тос тосолгоонд 7,665.0 мянган төгрөг, нийт 33,339.9 мянган төгрөг зарцуулсан боловч техник ашиглалтын картад бичилт, тэмдэглэл хийгдээгүй, нормын дагуу сэлбэг хэрэгслийг авч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сэлбэг хэрэгсэл худалдан авах бүртээ техник ашиглалтын картад бүрэн бичилт хийж жолооч нараар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	АЗДТГ	9	397,391.9	1	23,500.0	1	2,700.0	5	367,463.9	2	3,728.0